



АШУУИС

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

1942

ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААН

ISBN 99929-81-31-8

Vol.18, № 1, (65) 2022

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

Гэр бүл дэх ахмад болон залуу үе хоорондын харилцаанд нийгмийн сүлжээний үзүүлэх нөлөө

У.Номин-Эрдэнэ¹, М.Еркебулан², Г.Золжаргалан¹, М.Сугармаа^{1*}

¹АШУУИС, НЭМС, Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим
²АШУУИС, НЭМС, Эпидемиологи, биостатистикийн тэнхим
Цахим шуудан: *sugarmaa@mnuu.edu.mn, Утас: 99248787

Түлхүүр үг:

Фейсбүүк интервенц
Ойр дотно байдал

Товч утга:

Үндэслэл: Хүмүүс хоорондын харилцааны нэг хэлбэр нь үе хоорондын харилцаа юм. Энэ дотроо эмээ, өвөө ач, зээгийн хоорондын эерэг харилцаа нь нийгмийн дэмжлэгийн нэг эх сурвалж гэж үздэг¹. Хүүхдүүд бага насандаа өвөө, эмээтэйгээ ойр дотно байдаг ч том болохын хэрээр энэ харилцаа хөндийрдөг байна. Өвөө, эмээ болон ач, зээгийн харилцааг удаан хугацааны туршид тогтвортой хадгалахын тулд хэн хэнээс нь хүчин чармайлт шаарддаг². **Зорилго:** Нийгмийн сүлжээгээр дамжуулан өвөө, эмээгийн дурсамжийг ач, зээ нартай хуваалцах нь тэдний ойр дотно байдал, одоогийн харилцааг сайжруулахад хэрхэн нөлөөлж буйг судлах. **Арга, аргачлал:** Судалгааг квази туршилтын загвараар 2018-2019 онд Улаанбаатар хотоос 60 залуучууд буюу ач, зээ нарыг хамруулсан. Ач, зээ нарыг интервенцийн болон хяналтын гэсэн 2 бүлэгт хуваасан. Интервенцийн бүлэгт 30 өвөө, эмээгээс зураг түүхийг цуглуулан авч фейсбүүк (secret) нууц группээр дамжуулан ач, зээд үзүүлэн интервенц явуулсны дараа өвөө, эмээ ач, зээгийн хоорондын харилцааны үзүүлэлтийн өөрчлөлтийг үнэлсэн. Харилцааг үнэлэхдээ харилцааны ойр дотно байдал, харилцааны чанар, хүчин чармайлт, сэтгэл зүйн нийцэл, харилцааны сэдэв гэсэн бүлэг асуумжуудыг ашигласан. **Үр дүн:** Фейсбүүкээр зураг хуваалцсан интервенцийн бүлэгт сэтгэл зүйн нийцлийн оноо 0.381-ээр нэмэгдсэн бөгөөд энэ зөрүү нь Кохений нөлөөллийн хэмжээнд их зөрүүтэй буюу хангалттай байна. Зөвхөн энэ үзүүлэлт дээр түүврийн чадал 0.77 буюу 77%-тай Р утга=0.017 В=1-0.017=98% байна. Энэ нь өвөө, эмээгийнхээ талаар зураг түүхийг хуваалцсан ач, зээ нарын хувьд сэтгэл зүйн нийцэл буюу өвөө эмээдээ итгэх итгэл, амьдралын талаарх үзэл бодол, ёс суртахуун, хоорондын холбоо болон нээлттэй байдал нэмэгджээ. **Дүгнэлт:** Өвөө, эмээгийн зураг, түүхтэй танилцсан фейсбүүк интервенцийн үр дүнд ач, зээ нар хувьд өвөө, эмээтэй харилцах сэтгэл зүйн нийцэл статистик ач холбогдол бүхий сайжирсан бол бусад үзүүлэлтүүдийн нөлөө дунд болон бага хэмжээгээр нэмэгдсэн байна.

Үндэслэл: Гэр бүл дэх үе хоорондын харилцааны талаар олон судалгаанд өвөө, эмээ болон ач, зээ нарын харилцааг судалсан байдаг. Ахмад настнууд ач, зээтэйгээ ойр дотно байж, хайрлах нь тэдэнд ач тустай төдийгүй ач, зээ нартаа ойр, дотно байгаагаа илэрхийлэх нь тэдний ганцаардал, стрессийг бууруулах зэргээр сэтгэл зүйн сайн сайхан байдалд эергээр нөлөөлдөг¹. Харин залуучуудын хувьд үе хоорондын харилцаа нь өвөө, эмээтэйгээ харилцах харилцаанаас ихээхэн хамаардаг³. Ач, зээ нарт энэ харилцаа нь сэтгэл зүйн,

танин мэдэхүйн хувьд ач тустай байдаг³. Өвөө, эмээ бол нийгмийн дэмжлэг, гэр бүлийн түүх, нэр хүнд, хөгжлийн эх сурвалж юм¹. Хүүхдүүд бага насандаа өвөө, эмээтэйгээ ойр дотно байдаг ч том болохын хэрээр энэ харилцаа хөндийрдөг байна.

Өвөө, эмээ болон ач, зээгийн харилцааг удаан хугацааны туршид тогтвортой хадгалахын тулд хэн хэнээс нь хүчин чармайлт шаарддаг². Ахмад настуудын хувьд ач, зээтэйгээ харилцахад гарч байгаа хамгийн түгээмэл бэрхшээлүүдийг тоймлож үзэхэд

газарзүйн хувьд үр хүүхэд, ач, зээгээсээ хол амьдрах, харилцааны эх сурвалжуудын хязгаарлагдмал байдал, харилцаандаа санаа тавихгүй байх нь үе хоорондын харилцааг хямраах (эрсдэлд оруулах) бас нэг хүчин зүйл гэж үздэг зэрэг нь илүүтэй байна⁴. Эдгээр бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд нийгмийн сүлжээнд түшиглэсэн интервенцийг хэрэгжүүлэх боломжтой юм. Энэ чиглэлээр хийгдсэн тойм судалгаанаас үзэхэд компьютер, интернетийн технологи нь настнуудын ганцаардлыг багасгаж байгааг тогтоосон^{5,6}. Мөн үе хоорондын харилцаанд залуу үеийнхний талаас анхаарсан интервенц цөөн байгаа зэргээс үндэслэн бид энэ судалгааг хийсэн.

Зорилго: Нийгмийн сүлжээгээр дамжуулан өвөө эмээгийн дурсамжийг ач, зээ нартай хуваалцах нь тэдний ойр дотно байдал, одоогийн харилцааг сайжруулахад хэрхэн нөлөөлж буйг судлах.

Зорилт:

1. Ач, зээ нарын өвөө, эмээтэйгээ харилцах харилцааны ойр дотно байдал, харилцааны чанар, тэдний зүгээс гаргаж буй хүчин чармайлт, хичээл зүтгэл, сэтгэл зүйн нийцлийг тодорхойлох.
2. Нийгмийн сүлжээгээр өвөө, эмээгийн хуучин зураг, түүний түүхийг ач, зээ нартай хуваалцах интервенцийн үр дүнг ач, зээ нарын өвөө, эмээтэйгээ харилцах харилцааны ойр дотно байдал, харилцааны чанар, тэдний зүгээс гаргаж буй хүчин чармайлт, хичээл зүтгэл, сэтгэл зүйн нийцэлд гарсан өөрчлөлтөөр үнэлэх


Арга, аргачлал: Судалгааны загвар, түүвэрлэлт: Квази туршилтын загвараар 2018 оны 1-р сараас 2019 оны 10 сарын хооронд Улаанбаатар хотод амьдардаг оролцогчдыг доорхи шалгуурын дагуу судалгаанд хамруулсан. Үүнд:

Залуучууд буюу ач, зээ нар (оюутнууд)-ыг 1. 18-30 насны, 2. Тогтмол буюу 7 хоногт 2-3 эсвэл түүнээс олон удаа фэйсбүүк хаягаа шалгадаг, 3. Өвөө, эмээгээсээ тусдаа амьдардаг, 4. Өвөө, эмээтэйгээ 7 хоногт 1 -ээс бага удаа уулздаг;

Ахмад настнууд буюу өвөө, эмээ нарыг 1. Танин мэдэхүйн хувьд эрүүл, 2. 60-аас дээш насны, 3. Тэтгэвэрт гарсан, 4. Фэйсбүүк хаяггүй, 5. Амьдралын чухал дурсамжтай мөчүүдэд авахуулсан хамгийн багадаа 8 зурагтай байх гэсэн шалгуураар тус тус хамруулав.

Хуваарилалт: Хяналтын болон интервенцийн бүлэгт санамсаргүйгээр сонгох байсан боловч урьдчилсан судалгаагаар санамсаргүй интервенцийн бүлэгт оролцох оролцогч бага байсан учир хяналтын бүлгийн оролцогчдын нас, хүйс, харилцааны ойр дотно байдлаар интервенц бүлгийн оролцогчидтой ижилсүүлсэн.

Интервенц: Нийт 60 хос буюу өвөө, эмээ болон ач, зээ судалгаанд оролцсон. Судалгаанд оролцогчдыг 30, 30-аар интервенц болон хяналтын бүлэг болгон хуваасан. Интервенц бүлгийн 30 өвөө, эмээтэй уулзалт хийн, зураг түүхийг яриулж, цуглуулсан хуучны зургуудыг товч дурсамжийн хамт 7 хоног тутам фэйсбүүк нууц групп-д зөвхөн ач, зээд нь харагдах байдлаар нийтлэсэн. Харин хяналтын бүлгийн 30 өвөө, эмээ нь ямар ч зургаа ач, зээтэйгээ хуваалцаагүй. (Зураг 1)



Зураг 1. Судалгааны үе шат

Мэдээлэл цуглуулсан хэрэглэгдэхүүн:

- 1) Урьдчилсан асуумжаар оролцогч ач, зээ нарын фейсбүүк хэрэглээ, өвөө, эмээгийн талаарх тойм мэдээллийг авсан.
- 2) Суурь болон дараах үнэлгээний хүрээнд ач, зээ нарын өвөө, эмээтэйгээ ойр дотно байдлыг үнэлэхдээ дараах судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг ашигласан. Үүнд:
 - Бусдыг өөртөө хамаатуулах хэмжүүр: Гехтэрийн 2015 онд боловсруулсан “Бусдыг өөртөө хамаатуулах” хэмжүүрийг ашигласан. Энэ арга нь ойр дотно байдлыг хэмжих зурган тестийн арга бөгөөд 1-7 оноогоор хэмжигддэг. 1 оноо нь огт ойр биш болохыг илтгэдэг бол 7 оноо нь маш ойр дотно болохыг илэрхийлдэг⁷.
 - Харилцааны чанар: Бүмстер болон Фурман нарын 2008 онд боловсруулсан “Харилцааны чанарыг тодорхойлох” асуумжийг ашигласан. Энэ нь нөхөрсөг байдал, сэтгэл зүйн дэмжлэг, хүлээн зөвшөөрөлт, сэтгэл ханамж болон нууцыг хуваалцах гэсэн 5 дэд үзүүлэлтээр нийт 15 асуултын дунджаар харилцааны ойр дотно байдлыг илэрхийлнэ⁸.
 - Харилцаан дахь хүчин чармайлт, хичээл зүтгэл: Өвөө, эмээтэйгээ харилцах харилцаагаа хадгалахын тулд ач зээнарын зүгээс зориулж буй хүчин чармайлт, хичээл зүтгэлийг 1998 онд Разьбултын боловсруулсан харилцаа дахь хүчин чармайлт, хичээл зүтгэлийн үнэлэх 9 асуулт бүхий асуумжийг ашигласан⁹.
 - Бахархал: Өвөө, эмээгээрээ хэр их бахархдаг вэ нэг асуултаар үнэлсэн.
 - Харилцах ерөнхий ярианы сэдэв олддог эсэх, ихэвчлэн яриа өрнүүлдэг ярианы сэдвүүд болон хамгийн сүүлд ямар баяртай болон таагүй үйл явдал харилцаанд гарсаныг бичгэн хэлбэрээр хариулах 4 асуултыг ашиглав.
 - Сэтгэл зүйн нийцлийг тодорхойлох асуумж: Өвөө, эмээтэйгээ харилцах харилцааны сэтгэл зүйн нийцлийг тодорхойлохдоо Кели Кэмпбэлийн 2015 онд боловсруулсан сэтгэл зүйн нийцлийг тодорхойлох асуумжуудыг ашигласан¹⁰.

Судалгааны ёс зүй: АШУҮИС-ийн Судалгааны ёсзүйн хяналтын хорооны 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар (№2017/3-05) хэлэлцүүлж, судалгааг хийх зөвшөөрлийг авсан. Судалгаанд оролцогчдын сайн дурын үндсэн дээр оролцуулсан бөгөөд судалгааны эхэнд судалгааны үйл явц, ашиг тус, эрсдэл, нууцлалын талаар ач, зээ нар болон өвөө, эмээд таниулж, зөвшөөрлийн хуудсаар баталгаажуулсан.

Үр дүнгийн боловсруулалт: Үр дүнг “SPSS 25.0, G*Power 3.1” программуудыг ашиглан боловсруулалтыг хийсэн. Интервенцийн дараа хяналтын болон интервенц бүлгүүдийн харилцааг тодорхойлох үнэлгээний тоон хувьсагчдын ялгааг интервенцийн өмнөх хувьсагчдаар засварлан нэг хүчин зүйлийн ковариацийн шинжилгээ (one way ANCOVA test) аргыг ашигласан. Хэрэв p утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик үнэн магадлалтай гэж үзсэн. Хоёр бүлгийн үр дүнгийн зөрүүг Кохений нөлөөллийн хэмжээг (Cohen's d effect

size) тооцож, тухайн утга 0.3-аас эрс бага байвал бага, 0.5-аас эрс бага байвал дунд, 0.5 болон түүнээс дээш байвал их гэж үнэлсэн. Хоёр бүлгийн үр дүнгийн зөрүүг үнэлэхдээ тухайн зөрүүг үнэлэх дүнгийн чадлыг G*Power 3.1 программ ашиглан тооцсон. Ингэхдээ Кохений нөлөөллийн хэмжээг (Cohen's d effect size), статистик ач холбогдлын түвшин (α), 2 бүлгийн тохиолдлын тоо (n_1 , n_2) гэсэн утгуудыг ашиглан тооцсон.

Үр дүн: Судалгаанд оролцсон нийт 60 ач, зээ нарын дундаж нас 25 байв. Насны бүлгээр авч үзвэл 25-30 насны залуучууд 40 хувь буюу ихэнх хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд 65% нь эмэгтэйчүүд байв. Интервенц болон хяналтын бүлгийн ач, зээ нарын нас, хүйсийн харьцаа ойролцоо байсан. Интервенц бүлэг буюу зураг, түүхээ хуваалцсан 30 эмээ, өвөө нарын нарын дундаж нас 75 байсан ба, насны бүлгийн хувьд 64-81 насны өвөө, эмээ нар оролцсон. Хүйсээр авч үзвэл дийлэнх буюу 70 хувь нь эмэгтэй байв.

Судалгааны эхэнд ач, зээ нарын өвөө, эмээтэйгээ ойр дотно байдлыг зурган аргаар үнэлэхдээ дунджаар 4.57 оноо байна. Харилцааны чанарыг тодорхойлдог 5 дэд үзүүлэлтийн найдвартай байдлыг үнэлэхдээ нөхөрсөг байдал (кронбах алфа=0.66) нууцаа хуваалцах (0.92), сэтгэл ханамж (0.83), сэтгэл санааны дэмжлэг (0.83), хүлээн зөвшөөрөх (0.86) буюу хангалттай нийцтэй байна. Нөхөрсөг байдлыг үнэлэх 3 асуултын хариултын дунджаас харахад “Хамтдаа хөгжилдөх цаг хэр гардаг вэ?” асуулт нь 2.6, “Тадуур гарч, хамтдаа юм хийх цаг хэр гардаг вэ?” гэсэн асуултанд хамгийн бага буюу 2.06 байгаагаас ач, зээ нар нь өвөө, эмээтэйгээ хамт байх цаг нь бага байна. Харин “Хамт байхдаа хөгжилтэй байдаг уу?” гэсэн асуултанд хамгийн өндөр буюу 3.99 байгаа нь цаг гарсан тохиолдолд өвөө, эмээтэйгээ байхад хөгжилтэй байдаг нь илүүтэй байна.

Нууцаа хуваалцах талаарх асуултанд дунджаар 2.5 оноогоор хариулсан байв. Үүнээс ач, зээ нар өвөө, эмээ нартаа өөрт тулгарсан асуудал, нууцаа хуваалцах нь бага байна. Сэтгэл ханамжийн 3 асуултын дундаж оноо 4.2-оос дээш байсан бөгөөд өвөө, эмээтэйгээ харилцах харилцаандаа нийтдээ сэтгэл ханамжтай байгаагийн дотор эмээ, өвөөтэйгээ харилцах нь тэдэнд таатай байдаг нь хамгийн өндөр оноотой байна. Сэтгэл санааны дэмжлэгийн талаар асуултанд хариулсан байдлаас үзэхэд өөрт тулгарсан асуудал, бэрхшээлээ ярьж хандах нь бага (2.55) бол өвөө, эмээгээ ойлгож туслаж зөвлөнө гэдэгт итгэдэг болон уйтгарлаж уурласан үед сэтгэлийг сэргээж тайвшруулж чадна (3.93; 3.8) гэж хариулжээ. Үүнээс харахад өвөө, эмээгээ ойлгож туслаж чадна гэдэгт итгэлтэй байдаг ч төдийлөн ханддаггүй байна. Хүлээн зөвшөөрөх бүлэг асуултад оролцогчид (4.31-4.44) хариулсан байсан ба өвөө, эмээгийн зүгээс ач, зээ нараараа бахархаж, байгаагаар нь хүлээн зөвшөөрч, магтаж байдаг нь харагдаж байна. Харилцаан дахь хичээл зүтгэл, хүчин чармайлтыг (кронбах алфа=0.91) 9 асуултаар хэр зэрэг санал нийлж байгаагаар нь 0-8 оноогоор үнэлдэг. Өвөө, эмээтэйгээ харилцах харилцаа нь өөрийгөө хэн гэж боддогтой нь холбоотой гэсэн асуултад 6.46

буюу хамгийн өндөр оноогоор хариулжээ. Мөн өвөө, эмээтэйгээ хамт өнгөрүүлсэн үнэтэй дурсамжууд олон байдаг, сэтгэл санааны ойр дотно байдлыг мэдэрдэг боловч ихэнх нь харилцаандаа цаг гаргах нь бага байдаг болох нь харагдаж байна.

Судалгаанд оролцогч залуусын өвөө, эмээтэйгээ харилцах давтамжийг үнэлэхэд дунджаар сардаа 1-2 удаа биечлэн уулзах болон утсаар ярьдаг боловч мессеж бичих, видео колл, фейсбүүк гэх мэт нийгмийн сүлжээг ашиглаж огт харилцдаггүй байв. Өвөө, эмээ ач, зээ хоорондын харилцааны сэтгэл зүйн нийцлийг (кронбах алфа=0.92) тодорхойлох асуумжаас харахад ач, зээ нар өвөө, эмээдээ итгэдэг, өвөө, эмээгээ ч өөрт нь итгэдэг төдийгүй харилцахад ямар нэгэн бэрхшээлгүй гэж хариулсан байсан. Харин амьдралын зорилго, амьдралын талаархи үзэл бодол, үнэт зүйл, боловсролын түвшин, ёс суртахууны хувьд ялгаатай гэж үзэж байсан. Өвөө, эмээтэйгээ харилцахад ярианы сэдэв олдохгүй байх асуудал гардаггүй гэсэн байв.

Ихэвчлэн ямар сэдвээр ярилцдаг талаархи асуумжид ихэнх нь ач, зээгийн хичээл, ажил, өвөө, эмээгийн эрүүл мэнд болон гэр бүл хамаатнуудынхаа

талаар ярилцдаг байв. Интервенц буюу бид өвөө, эмээгийн хуучны зургийг хуваалцсанаар ач, зээ нарын өвөө, эмээтэйгээ харилцах харилцааны ойр дотно байдал, харилцааны чанар, тэдний зүгээс гаргаж буй хүчин чармайлт, хичээл зүтгэл, сэтгэл зүйн нийцэлд гарсан өөрчлөлтийг үнэлсэн үр дүнг интервенцийн өмнө болон дараах өөрчлөлтөөр үнэллээ. Нөхөрсөг байдлын хувьд интервенц бүлэгт хяналтын бүлгээс 0.164 оноогоор нэмэгдсэн байв. Энэ зөрүү нь Кохений нөлөөллийн хэмжээгээр дунд зэрэг байна ($p=0.235$; түүврийн чадал 0.316; $B=0.684$). Фейсбүүкээр зураг хуваалцсан интервенцийн бүлэгт сэтгэл зүйн нийцлийн оноо 0.381-ээр нэмэгдсэн бөгөөд энэ зөрүү нь Кохений нөлөөллийн хэмжээнд их зөрүүтэй буюу хангалттай байна. Зөвхөн энэ үзүүлэлт дээр түүврийн чадал 0.77 буюу 77%-тай P утга= 0.017 $B=1-0.017=98\%$ байна. Энэ нь өвөө, эмээгийнхээ талаар зураг түүхийг хуваалцсан ач зээ нарын хувьд сэтгэл зүйн нийцэл буюу өвөө, эмээдээ итгэх итгэл, амьдралын талаархи үзэл бодол, ёс суртахуун, хоорондын холбоо болон нээлттэй байдал нэмэгдсэн гэдгийг харуулж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Интервенцийн дараах өөрчлөлтийн үр дүн

Үзүүлэлт	Нийт	Интервенц	Хяналтын бүлэг	Зөрүүний дундаж	Cohen's d effect size		Sample power	p утга
	дун±с.х.	дун±с.х.	дун±с.х.					
Нөхөрсөг байдал	2.83±0.53	2.91±0.53	2.75±0.53	0.164	0.31	Дунд	0.316	0.235
Нууцаа хуваалцах	2.67±0.64	2.7 ±0.64	2.64±0.64	0.057	0.09	Бага	0.095	0.731
Сэтгэл ханамж	4.3±0.57	4.41 ±0.58	4.19±0.58	0.214	0.37	Дунд	0.395	0.161
Сэтгэл санааны дэмжлэг	3.37±0.8	3.29 ±0.8	3.45±0.8	-0.156	0.20	Дунд	0.180	0.457
Хүлээн зөвшөөрөх	4.21±0.67	4.3±0.67	4.12±0.67	0.176	0.26	Дунд	0.252	0.316
Бахархал	4.7±0.56	4.77±0.58	4.63±0.58	0.144	0.25	Дунд	0.236	0.360
Хичээл зүтгэл, хүлээн зөвшөөрөх	4.19±1.01	4.38±1.01	3.99±1.01	0.390	0.38	Дунд	0.418	0.142
Харилцааны давтамж	1.53±0.26	1.54±0.26	1.52±0.26	0.015	0.06	Бага	0.077	0.824
Сэтгэл зүйн нийцэл	3.65±0.59	3.84±0.6	3.45±0.6	0.381	0.64	Их	0.771	0.017
Ерөнхий харилцааны сэдэв	3.9±0.53	4.02±0.54	3.78±0.54	0.234	0.44	Дунд	0.494	0.099
Ойр дотно байдал	4.37±1.25	4.55±1.25	4.19±1.25	0.358	0.29	Дунд	0.282	0.275
Нийт (дараах)	3.61±0.39	3.69±0.39	3.53±0.39	0.151	0.39	Дунд	0.423	0.142

Хэлцэмж: Бидний судалгаа нь гэр бүлдэх үе хоорондын харилцаа буюу өвөө, эмээ ач, зээ хоорондын харилцааны байдал болон фейсбүүкээр интервенц явуулах замаар тэдний харилцаанд эерэг өөрчлөлт гарсан эсэхийг үнэлсэн юм. Ингэхдээ нийгмийн сүлжээг ашиглан өвөө, эмээгийн түүхийг ач, зээ нартаа хуваалцсанаар ач, зээ нарын эмээ, өвөөтэйгээ харилцах харилцааны хамгийн тогтвортой үзүүлэлт болох сэтгэл зүйн нийцэл нэмэгдсэн нь гол үр дүн байв. Бусад үзүүлэлтийн хувьд түүврийн чадал (Sample power) бага байгаа нь түүврийн хэмжээ хангалтгүй байгааг илтгэж байгаа учир интервенцийн дараа ялгаагүй буюу зөрөөгүй байгаа гэж батлахаар хэмжээнд хүрэхгүй байгаа юм.

Түүврийн хэмжээг нэмэгдүүлбэл нөлөөллийн хэмжээ ихсэж, зөрүү нь нэмэгдэх магадлалтай. Түүврийн хэмжээ хангалтгүй байгаа ч интервенц

явуулсан 30 хүний хувьд дунд зэрэг зөрүү гарсан байгаа нь түүвэр нэмэгдвэл нөлөөлөл ихсэх магадлалтай харуулж байна. Манай судалгааны хувьд өвөө эмээтэй, тэднээсээ тусдаа амьдардаг, өвөө эмээтэйгээ сард 1-2 удаа уулздаг шалгууруудыг хангасан оролцогчид хангалттай хэмжээнд байсан боловч судалгаанд оролцохыг зөвшөөрөх нь бага байсан юм. Эндээс харахад өвөө эмээ болон ач зээгийн харилцаа ойр дотно биш байх магадлалтай, энэ талаар цаашид судлах шаардлагатай юм. Энэ нь өөр өөр цаг үед амьдарч, амьдралын өөр үе шатуудыг туулсан, харилцааны чадвар, үг хэллэгийн хувьд ялгаатай байх нь үе хоорондын харилцаанд байдаг бас нэгэн бэрхшээл гэж үзсэн Каллиопушкагийн судалгааны үр дүнтэй холбож болох юм¹.

Дурсамж хуваалцах явцад өвөө эмээ нар өөрийн өнгөрсөн түүхийг ярихдаа маш их баяр баясгалантай

болж, сэтгэл хангалуун байгаа нь анзаарагдаж байв. Вебстерийн 2007 онд хийгдсэн дурсамж хуваалцах болон насанд хүрэгчдийн тод дурсамжуудыг судалсан судалгаанд 18-95 насны 198 оролцогч оролцсон¹¹. Ахмад настангуудын тод дурсамжууд ихэвчлэн эерэг дурсамжууд байсан таагүй үйл явлуудыг амьдралд чухал үйл явдал гэж үзэхээ больсон байдаг ба өөрийн сонирхол, баяр баясгалангийн талаар ярьж сэтгэл хангалуун байсан нь манай судалгааны үр дүнтэй нийцэж байгаа юм¹⁰. Reminiscence Functions Scale (RFS) ашигласан дурсамж хуваалцах талаар судалгаанууд байдаг боловч нийгмийн сүлжээг ашигласан судалгаа одоогоор байхгүй байгаа юм¹².

Үе хоорондын харилцааны талаар ажиглалтын судалгаа цөөнгүй байдаг ч интервенц судалгаа тэр дундаа нийгмийн сүлжээг ашигласан нь ховор байсан тул бид өөр судалгаатай харьцуулах боломжгүй байлаа. Интервенцийн өмнө өвөө, эмээг эцэг эхийн аль талын өвөө эмээ гэдгийг асуумждаа оруулсан бол Монголын нөхцөлд ач, зээ нар аль талын өвөө эмээтэйгээ илүү ойр дотно харилцаатай байгааг судлаж, илүү мэдээлэлтэй байх боломжтой байсан. Цаашид гэр бүл дэх үе хоорондын харилцааны талаар энэ төрлийн судалгааг хийхэд түүврийн хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хот хөдөөд өргөжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт:

1. Ач, зээ нарын өвөө, эмээтэйгээ ойр дотно байдал харьцангуй ойр, хамт байх цаг бага байдаг ч хамт байхдаа сэтгэл зүйн хувьд нийцтэй, сэтгэл ханамжтай байна.
2. Өвөө, эмээгийн зураг, түүхтэй танилцсан фейсбүүк интервенцийн үр дүнд ач, зээ нар хувьд өвөө, эмээтэй харилцах сэтгэл зүйн нийцэл статистик ач холбогдол бүхий сайжирсан бол бусад үзүүлэлтүүдийн нөлөө дунд болон бага хэмжээгээр нэмэгдсэн байна.

Ном зүй:

1. Kalliopuska, M. Relations of retired people and their grandchildren. *Psychological Reports*, 1994. 75(3), 1083-1088.
2. Mansson, D. H. Grandparents' Expressed Affection for Their Grandchildren: Examining The Grandparents' Own Psychological Health. *Communication Research Reports*, 2014. 31(4), 329-338.
3. Margaret Sims, Maged Rofail, The experiences of grandparents who have limited or no contact with their grandchildren. *Journal of aging studies*. 2013. 27(4):377-386
4. Bangerter, L. R., & Waldron, V. R. Turning points in long distance grandparent-grandchild relationships. *Journal of aging studies*, 2014. 29, 88-97.
5. Choi, M., Kong, S., & Jung, D. Computer and internet interventions for loneliness and depression in older adults: a meta-analysis. *Healthcare informatics research*. 2012. Sep. 18(3), 191-198. <https://dx.doi.org/10.4258%2Fhir.2012.18.3.191>
6. Chen, Y. R., & Schulz, P. J. The effect of information communication technology interventions on reducing social isolation in the elderly: A systematic review. *Journal of medical Internet research*. 2016 Jan 28;18(1):e18. doi: 10.2196/jmir.4596
7. Gächter S, Starmer C, Tufano F. Measuring the Closeness of Relationships: A Comprehensive Evaluation of the 'Inclusion of the Other in the Self' Scale. 2015; PLoS ONE 10(6): e0129478. <https://doi.org/10.1371/journal.pone.0129478>
8. Buhrmester, D. Furman, W. The Network of Relationships Inventory: Relationship Qualities Version. Unpublished measure, University of Texas at Dallas. 2008;
9. Rusbult, C. E., Martz, J. M., & Agnew, C. R. The investment model scale: Measuring commitment level, satisfaction level, quality of alternatives, and investment size. *Personal Relationships*. 1998; 5: 357-391.
10. Campbell, K., et al. Friendship chemistry: An examination of underlying factors. *The Social Science Journal*. 2015. 52(2). 239-247. <https://doi.org/10.1016/j.soscij.2015.01.005>
11. Webster, J.D., Gould, O. Reminiscence and vivid personal memories across adulthood. *The International Journal of Aging and Human Development* 2007. 64(2), 149-170
12. Webster, J.D. Construction and validation of the reminiscence functions scale. *Journal of Gerontology*. 1993. 48 (5), 256-262